

лики Индии и её миролюбивой внешней политики является Джавахарлал Неру-один из руководителей национально-освободительного движения индийского народа. Он сыграл большую роль направленности политики неприсоединения Индии.

Приверженность к делу мира, борьба за обеспечение равноправия как в политических, так и в экономических отношениях между газартай байсны государствами, нетерпимость к проявлениям империализма, расизма, колониализма напартеида — таковы основные принципы политики неприсоединения, проводимой правительством Индии.

Антимпериалистический, миролюбивый курс внешней политики Индии создает благоприятные условия для преодоления отсталости, унаследованной страной от грабительского колониального господства британского империализма и способствует дальнейшему возрастанию роли Индии в международных делах.

Автор статьи делает вывод, что движение неприсоединения, одним из инициаторов которого является Индия, ныне становится одним из влиятельных, прогрессивных факторов в международных отношениях. Индия, являясь одним из активных членов этого движения, играет важную роль в укреплении антиимпериалистической на правленности движения неприсоединения и вносит большой вклад в борьбу народов за укрепление мира и безопасности в Азии и во все мире.

ХУВЬСГАЛТ ОЛОЛТОО БАТАТГАЖ БАЙГАА НЬ

Б. Батболд

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Никарагуагийн ард түмний хагас зуун жил шахам талхин дарлаж байсан Латин Америкийн хамгийн харгис дэглэмийн нэг болох Сомосын дарангуйлал зэвсэг барин боссон ард түмний тэмцлийн үр дүнд одоогоос зургаан жилийн өмнө түлхэгдэн унасан билээ.

Никарагуагийн ард түмний хувьсгалт тэмцлийг Сандиногийн үндэсний Чөлөөлөх фронт (СҮЧФ) удирдсан юм. Никарагуа дахь шинэ амьдралын үйл явц эдүгээ нарийн төвөгтэй нэлээд бэрхшээлтэй нөхцөлд явагдаж байна. 1979 оны 7-р сарын 19-нд ялсан хувьсгалын анхны өдрөөс эхлэн Төв Америкийн энэ орны ард түмэн хоёр фронт дээр нэгэн зэрэг тэмцэл явуулсаар байна. Үүнд нэг талаас хуучин нийгмийн хүнд бэрх хоцрогдлыг гэтлэн давах, нөгөө талаас эрх чөлөө, тусгаар тогтнолоо хувьсгалын дайснуудаас зэвсэг барин хамгаалах явдал болж байна.

Сандиногийн ардын хувьсгалын ялалтаас хойшхи өнгөрсөн таван жилд Никарагуагийн нийгмийн амьдралд гүн гүнзгий дэвшилт өөрчлөлтүүд гарлаа. Юуны өмнө тус оронд хувьсгалт ардчилсан төр тогтож, улс төрийн шинэ системийн үндэс тавигдан нийгэм—эдийн засгийн чухал өөрчлөлт, шинэтгэл хийгдэв.

Одоогийн дотоод, гадаадын ээдрээтэй, хүнд нөхцөлд Никарагуагийн үндэсний сэргэн мандалтын засгийн газар Сомосын харгис дэглэмийн үлдээсэн хуучин нийгмийн эрх тэгш бүс, байдал, эдийн зас-

гийн хоцрогдол, ажилгүйдэл, гуйланчлал зэргийг арилгах, шинэ нийгмийн үндсийг тавихад үлэмж анхаарлаа хандуулж билээ.

Сомосын дэглэм бол Латин Америкийн үе залгамжилсан фашист бурангуй дэглэмийн нэг үлдэгдэл байсан юм. Сомосын гэр бүлийнхэн Никарагуагийн үндэсний баялгийг тонон дээрэмдэж, түүний гуравны нэг орчмыг гартаа атгаж байсан бөгөөд гадаадын хэвлэлийн мэдээгээр зөвхөн дарангуйлагч сомосын эзэмшилд нисэх онгоцны «Ланика» компани, хөлөг онгоцны «Маменик» компани, «Висьен» хэмээх хэвлэлийн газар, кофены 46 тариалангийн газар, хөдөө аж ахуйн 52 эдлэн газартай байсны гадна Америкийн монополитнуудтай хамтран Никарагуагийн үнэт цаасны 50 орчим хувийг эзэмшиж байжээ. Иргэний дайны жилүүдэд Сомосын шууд мэдэлд байсан үндэсний гвардчууд хэмээх харгис цагдаагийн залхаан цээрлүүлэх байгууллага дарангуйллыг эсэргүүцсэн өчүүхэн төдий сэжгээр өдөр бүр 6—7 хүнийг баривчлан устгадаг байв. Түүнчлэн Сомосын дэглэмд ард түмэн эх орончдын дэвшилт хөдөлгөөнийг нухчин дарах зорилгоор АНУ нь цэрэг зэвсэг болон эдийн засгийн үлэмж тусламжийг үзүүлж байлаа. Гэвч Никарагуагийн эх орончид СҮЧФ-ын удирдлагаар Америкийн империализмын тусламжинд түшиглэсэн харгис дэглэмийн эсрэг зэвсэгт тэмцлээ үргэлжлүүлэн 1979 онд ялалтад хүргэсэн билээ.

Хувьсгалын ялалтын дараа никарагуагийн үндэсний сэргээн мандалтын засгийн газар өмнө үнэхээрийн нарийн түвөгтэй хүнд бэрх зориултууд тавигдаж байв. Иргэний дайнд 50 мянга орчим буюу хүн амын бараг 2 хувь нь амь үрэгдэж 600 мянга орчим хүн харгис дэглэмийн аллага тааллага, залхаан цээрлүүлэлийн уршгаар эх орноосоо дүрвэн зайлсан байлаа. Хөвөнгийн болон хөдөө аж ахуйн бусад гол тариалангийн талбай сүйдэгдэж, улсын санхүү хоосорсон байв. Түүнчлэн харгис дэглэмийнхэн гадаадын улс оронд 1,6 млрд гаруй долларын өр тавьжээ. Ийм нөхцөлд Сандиногийн үндэсний сэргээн мандалтын засгийн газар улс орноо сэргээн босгож бүтээх асар их ажлыг түүхэн богино хугацаанд амжилттай шийдвэрлэж байна. Юуны түрүүнд Сомосын гэр бүлийнхний эзэмшилд байсан өмчийг улсын болгож улс—хоршооллын секторыг байгуулан, эдийн засгийн үндсийг тавьжээ. Түүнчлэн дотоодын бүх банкныг улсын болгосон бөгөөд гадаадын банкны үйл ажиллагаанд зохих хязгаарлалт, хяналт тогтоожээ.

Никарагуад газрын шинэтгэл амжилттай хийж, хуучин нийгмийн үед газрын том хөрөнгөтний эзэмшилд байсан хөдөө аж ахуйн эдлэн газрыг хураан авч, газаргүй олон мянган тариачдад олгожээ. Никарагуагийн гадаадад гаргах гол бүтээгдэхүүн болох кофе, хөвөн, нишингийн тариалалт жилээс жилд улам бүр өсөн нэмэгдсээр байна. 1983 оны байдлаар эдгээр зүйлийн тариалалт түрүүчийн оныхоос 10 хувиар нэмэгдсэн бөгөөд нийт 300 сая орчим долларын хэмжээнд хүрсэн ажээ. Зөвхөн хөвөн хураалтын хэмжээг 1984 онд 150 мянган тоннд хүргэхээр төлөвлөснийг 173 мянган тоннд хүргэж төлөвлөгөөгөө амжилттай давуулан биелүүлжээ.

Түүнчлэн нийгэм, эдийн засаг соёлын салбарт авч буй хувьсгалт ардчилсан арга хэмжээний үр дүнд үндсэн өөрчлөлт гарлаа. Тухайлбал уул уурхайн болон загасны аж ахуй олзворлолт, банк даатгалын бүх системд улсын хяналт тогтжээ. Түүнчтэн худалдааны системийн 50 гаруй хувийг улс хянаж байна.

Сандиногийн фронтын удирдлагын мэдэгдсэнээр Никарагуагийн эдийн засаг нь өнөөгийн хөгжлийн онцлогийн улмаас хөдөлмөрийн ашиг сонирхолд үйлчлэх улсын болоод хувийн аж ахуйг хосолсон хо-

лимог эдийн засгийг хөгжүүлэх зорилт тавьж байгаа ажээ. Никарагуад ардын боловсрол, эрүүлийг хамгаалах салбар үлэмж амжилт олжээ. Хувьсгалын ялалтын өмнө Никарагуагийн хүн амын 70 хувь, түүний дотор хөдөөгийн оршин суугчдын 90 хувь нь бичиг үсэг мэддэггүй байсан бол энэ үзүүлэлт одоогийн байдлаар 10 орчим хувь хүртэл буурчээ. Хувьсгалын жилүүдэд олон тооны эмнэлэг, асрамжийн газар байгуулагдсан бөгөөд полиомиелит, хумхаа өвчний голомтыг устгажээ. Сүүлийн хоёр жил гаруй хугацаанд империалист харгис хүчин зарлаагүй дайн үргэлжлүүлэн хорлон сүйтгэх ажил явууллага тасралтгүй өдөөсөөр ирсний улмаас үлэмж хэмжээний хөрөнгө мөнгийг батлан хамгаалахад зарцуулж байгаа боловч 1983 онд улс орны эдийн засгийн үзүүлэлт 5 хувьд хүрсэн нь Латин Америкт Кубын дараа орж байна.

Түүнчлэн Никарагуад ардчиллыг хөгжүүлж, төрийн байгууллыг бэхжүүлэх талаар улс орны өвөрмөц нөхцөлд тохирсон тодорхой алхмууд хийгдэв. Тухайлбал, Никарагуагийн төрийн зөвлөл өнгөрсөн онд цэргийн алба хаах тухай шинэ хууль баталсан явдал улс орныг батлан хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ хуулиар Никарагуагийн 17-50 насны эрэгтэйчүүд, 18-40 насны эмэгтэйчүүд 2 жилийн хугацаагаар цэргийн алба хаах үүрэгтэй юм.

Никарагуагийн дотоод, гадаад байдал хэцүү байгаагийн улмаас 1982 оны 3-р сараас эхлэн улс орон даяар онцгой байдал зарласан боловч улс төрийн 10 нам ажиллаж үйл ажиллагаагаа явуулж байна.

Үндэсний сэргэн мандалтын засгийн газрын удирдах зөвлөл 1984 оны 11-р сарын 4-нд бүх нийтийн сонгууль явуулж улсын ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч Үндэсний Ассамблейн депутат нарыг сонгохоор бэлтгэсэн нь улс төр, үзэл суртлын чухал арга хэмжээ болсон юм.

Сонгуульд улс төрийн хамгийн өргөн байгууллага болох Сандиногийн Үндэсний Чөлөөлөх Фронт сонгогчдын дийлэнхи олонхийн санал (67%) авсан явдал улс төрийн чухал ач холбогдолтой үйл явдал болов. Мөн сонгуульд 1,5 сая сонгогчдын 82 % оролцсон нь Никарагуа түмний улс төрийн тод харуулсан юм. Түүнчлэн сонгуулийн явц, үр дүнтэй танилцах зорилгоор АНУ, Канад болон Европ, Латин Америкийн 20 гаруй орноос улс төр, олон нийтийн нэрт зүтгэлтнүүд, урлаг, соёл, шажинтаны төлөөлөгчид зэрэг 500 гаруй ажиглагчид оролцож уг сонгууль нь бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн журам, горимын дагуу амжилттай явагдсаныг гэрчилсэн билээ.

Ийнхүү дотоод, гадаадын харгис хүчин Никарагуагийн сонгуулийг нураан унагаах гэсэн боловч ямар ч амжилт олоогүй, харин ард түмний ялалтаар төгссөн юм.

Олон улсын тавцанд явуулж байгаа Бүгд Найрамдах Никарагуа Улсын гадаад бодлогын чиг шугам дэлхийн дэвшилт улс түмний талархал дэмжлэгийг олж байна. Никарагуагийн үндэсний сэргэн мандалтын засгийн газар тусгаар тогтнох эрх, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний зарчимд үндэслэсэн харилцан ашигтай байх харилцааг дэлхийн бүх улс түмэнтэй тогтооход бэлэн гэдгээ Никарагуад ардын хувьсгал ялсан өдрөөс эхлэн тунхаглаж, гуйвалтгүй баримталсаар байна. Никарагуа улсын гадаад бодлого нь империализм, колоницлол, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг эсэргүүцэж үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэж байгаа бүх улс түмэнтэй эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлсэн бодлого явуулж байна. Үүнийг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Байнгын бус гишүүнээр Никарагуа улсыг 1982 онд сонгоход дэлхийн 104 орон саналаа өгсөн явдал гэрчилсэн юм.

БННУ нь Төв Америкт бий болсон хурцадмал байдлыг намжаах, юуны түрүүнд улс төрийн замаар яриа хэлэлцээрийн үндсэн дээр шийдвэрлэх талаар үлэмж хүч чармайлт гаргаж байна. Тухайлбал, Мексикийн Мансанильо хоотд болж байсан Никарагуа, АНУ-ын уулзалтыг сэргээх, Америк-Никарагуагийн харилцааг хэвийн болгох үүднээс Никарагуа улс гадаадаас худалдан авах зэвсгээ түр зогсоосон ба Кубын цэргийн 100 орчим зөвлөхийг эх оронд буцаах зэрэг нэг талын зарим арга хэмжээ авсан юм.

БННУ нь дэлхийн олон улс орон, түүний дотор ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой олон талын өргөн харилцааг амжилттай хөгжүүлж байна.

Сүүлийн үед АНУ-ын эрх баригчид хувьсгалт Никарагуагийн эсрэг зарлаагүй дайнаа шатлан өргөжүүлж Никарагуаг цэрэг зэвсгийн хүчээр сүр далайлган түрэмгийлэл үйлдэхээр заналхийлж байгаа нь дэлхийн олон нийтийн сэтгэл санааг гүнээ түгшээж байна. АНУ-ын өнөөгийн засаг захиргаа Төв Америк дахь цэрэг дайны бэлтгэлээ хүчлэн нэмэгдүүлж, БННУ-д зэвсэглэн дайрах бэлтгэлээ ханган, энэ зорилгоо сүүлийн жилүүдэд АНУ болон Төв Америкийн зарим улс орны зэвсэгт хүчин оролцсон «Биг пайн—3», «Гранадеро—1», «Редикс—2» зэрэг нууц нэр бүхий цэргийн сургуулиуд хийж байгаа нь энэ бүс нутгийн байдлыг эрс хурцатгаж байна. Түүнчлэн сүүлийн үед Пентагоны болон тагнуулын төв газрын эрх баригчид Никарагуа улсын дотоод хэрэгт оролцох явдлаа гүнзгийрүүлэн, Сандиногийн хувьсгалын удирдагчдын амь насыг хороох хүртэл балмад төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхийг оролдож байна. Гэвч хувьсгалт Никарагуагийн зэвсэгт хүчин СҮЧФ-ийн дайчид АНУ болон бусад харгис хүчний өнгөлзлөгт эрс шийдвэртэй няцаалт өгч, хувьсгалын ололт амжилтаа өмгөөлөн хамгаалж байна. Эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалан тэмцэж байгаа Никарагуагийн ард түмний талд дэлхийн шударга хүн төрөлхтөн баттай зогсож дэмжиж байна. Империалист харгис хүчний уршгаар Никарагуагийн эргэн торонд бий болсон байдлыг яриа хэлэлцээний замаар зохицуулан шийдвэрлэхэд чиглэсэн «Контадорын бүлгийн»* хүчин чармайлт болон Никарагуагийн сэргэн мандалтын засгийн газрын энх тайванч санал, санаачлга нь цаг үеэ олсон чухал алхам мөн гэж монголын олон нийт дэлхийн энхийг эрхэмлэгч дэвшилт хүчний нэгэн адил үзэж байна.

Бүх дэвшилт хүн төрөлхтний халуун дэмжлэг талархлыг олж буй Никарагуагийн баатарлаг ард түмэн империалист харгис хүчний өнгөлзлөгийг таслан зогсоож, эрх чөлөө, тусгаар тогтнол, хувьсгалт ололт амжилтаа хамгаалж чадна гэдэгт монголын олон нийт итгэл төгс байна.

*«Контадорын бүлэг»-т Венесуэл, Колумб, Мексик, Панам улс ордог.

НИКАРАГУА ЗАЩИЩАЕТ СВОИ РЕВОЛЮЦИОННЫЕ ЗАВОЕВАНИЯ

(Резюме)

В результате вооруженной борьбы никарагуанского народа 19 июля 1979 г. в Манагуа был свергнут режим Сомоса, который являлся одним из жесточайших диктаторов в Центральной Америке, известных своим свирепым угнетением никарагуанского народа в течение почти полвека.

Вооруженную борьбу никарагуанского народа возглавил Сандинистский Национальный Фронт Освобождения (СФНО).

В настоящее время в Никарагуа осуществляются важные революционные социально-экономические преобразования в весьма трудных и сложных условиях.

Народ этой страны борется одновременно на двух фронтах: преодоление унаследованной от старого режима отсталости и нищеты с одной стороны с оружием в руках за свободу и независимость своей Родины в постоянной, непрекращающейся схватке с силами революции и империализма с другой.

В 1984 году в Никарагуа впервые в истории страны прошли свободные демократические всеобщие выборы, в которых приняла участие 82 процента избирателей.

Автор статьи отмечает, что необъявленная война администрации США против Сандинистской народной революции, особенно осуществляемые ныне американским империализмом экономическая блокада и иные меры в отношении этой молодой суверенной страны чреват большой опасностью усиления без того напряженной обстановки Центральной Америке. В условиях империалистической блокады трудящиеся Никарагуа под руководством своего авангарда — СФНО уверенно идут по пути строительства новой жизни, давая отпор агрессивным действиям империализма США и его приспешников. Национальное руководство и Правительство национального возрождения Никарагуа осуществляют социально-экономических преобразований в стране.

Вместе с тем сандинистское правительство настойчиво ищет пути смягчения взрывоопасной обстановки в Центральной Америке и предотвращения перерастания международного конфликта.

Социалистические страны и все миролюбивые силы, в том числе монгольский народ, как подчеркивает автор в заключении статьи, стоят на стороне правого дела никарагуанского народа, мужественно отстаивающего свободу и независимость своей Родины.